



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗӨВЛӨЛИЙН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

2023 оны 08 сарын 24 өдөр

Дугаар 15

Улаанбаатар хот

ХОТЫН СТАНДАРТ,
ХЯНАЛТЫН ГАЗАРТ

Нийслэлийн Засаг даргын зөвлөлийн 2023 оны 08 дугаар сарын 24-ний өдрийн 15 дугаар хуралдааны тэмдэглэлд:

“5.Иргэдийн эрүүл, аюулгүй, ая тухтай орчныг бүрдүүлэхэд хууль, норм дүрэм, стандартын хэрэгжилтийг хангуулах” тухай 2023 оны А/242 дугаар захирамжийн биелэлт, хэрэгжилтийн явцын талаар Хотын стандарт, хяналтын газрын дарга С.Төмөрдулам танилцуулав.

Энэ асуудалтай холбогдуулан:

1.Худалдаа үйлчилгээний байгууллагуудын барилгын гадна шат, довжоог хөгжлийн бэрхшээлтэй хүнд хүртээмжтэй байлгах, нийтийн эзэмшлийн гудамж талбайн тохижилт, цэвэрлэгээг тогтмолжуулах, явган хүний зам, гадна хаяг, рекламны самбар, бүрэн бүтэн байдал алдагдсан, эрсдэл үүссэн хүүхдийн тоглоомын талбайг засварлах, аюулгүй байдлыг хангуулж стандартад нийцүүлж ажиллахыг Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба (М.Баяраа)-нд, Хотын стандарт, хяналтын газар (С.Төмөрдулам)-т, Дүүргүүдийн Засаг дарга нарт;

2.Бүх шатны эрүүл мэндийн болон боловсролын байгууллагуудын гадна орчны тохижилт, аюулгүй байдлыг сайжруулах арга хэмжээг батлагдсан хотын стандартын дагуу зохион байгуулж үр дүн, тайлан мэдээг 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Хотын стандарт, хяналтын газарт нэгтгэн хүргүүлэхийг Нийслэлийн Эрүүл мэндийн газар (П.Эрхэмбулган)-т, Нийслэлийн Боловсролын газар (Б.Амартүвшин)-т;

3.Шинээр баригдаж буй барилга байгууламжуудын түр хашаа, хаалт, хамгаалалтын тор зэргийг стандартын дагуу угсарч, аюулгүй байдлыг хангуулсан эсэх, учирч болзошгүй аливаа эрсдэлийг бууруулахад чиглэсэн хяналт шалгалтыг эрчимжүүлж, хөдөлмөрийн аюулгүй ажиллагааг хангуулж, үр дүнг 2023 оны 09 дүгээр сарын 25-ны өдрийн дотор танилцуулахыг Нийслэлийн Хөдөлмөр, халамжийн газар (Б.Мөнхбаяр)-т; Нийслэлийн Хот байгуулалт, хөгжлийн газар (Ц.Тулга)-т;

4.Амралтын газар, жуулчны баазуудын гадны орчны тохижилт, ариун цэврийн байгууламж, бие засах газар, хог хаягдлын цэвэрлэгээ, үйлчилгээнд хөрсний бохирдлоос сэргийлэх арга хэмжээ авч, холбогдох үндэсний болон хотын стандартыг мөрдүүлж ажиллахыг Нийслэлийн Аялал жуулчлалын газар (Д.Батсүх)-т, Нийслэлийн Байгаль орчны газар (Р.Энхтайван)-т;

1110200334

5.Хотын стандартын хэрэгжилтийг сайжруулах талаар авах арга хэмжээний санал боловсруулж, танилцуулахыг Хотын стандарт, хяналтын газар (С.Төмөрдулам)-т тус тус үүрэг болгов” гэжээ.

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР

